



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүдэр ойн анги ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/13/-НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Аудитор: Утас: 7036-2442	Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Д.Чулуунцэцэг Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.mn
---	--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
4. АУДИТЫН ТАЙЛАН	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.5.1 Завсрын аудитын талаар	12
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Төлбөрийн акт	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



ХҮДЭР ОЙН АНГИ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Т.МӨНХТУУЛ ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.14 № САА-2024/ОА-СТА-ОАА
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Хүдэр ойн анги ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Хүдэр ойн анги ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын ИТХ-аар тус байгууллагын орлогын төлөвлөгөөг батлахдаа дансны эхний үлдэгдлийг нэмж тооцон баталсан байна.

Аудитын гол асуудал

Бараа материалын дансанд мод үржүүлгийн үрсэлгээг бүртгэж тайлагнаснаас үлдэгдэл өмнөх оноос материаллаг хэмжээгээр өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ИТХ-ын 2023 оны 133 дугаар тогтоолоор Хүдэр ойн анги ОНӨААТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааг “Хангалттай” гэж дүгнэсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	118,793,207.38	151,220,930.40
1.1.4	Авлагын дүн	1,083,045.90	1,013,581.56
	Ажиллагчидтай холбогдсон авлага		200,000
	Татвар,НДШ-ын авлага /ТӨҮГ/	1,083,045.90	813,581.56
	Бараа материал	2,293,500	29,985,426.17
	Аж ахуйн материал	1,996,300	4,691,826.91
	Дуусаагүй үйлдэрлэл		25,065,199.26
	Бусад хангамжийн материал	297,200	228,400
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	122,169,753.28	182,219,938.13
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	32,342,538.81	71,039,634.34
1.2.1	Үндсэн хөрөнгө	32,342,538.81	71,039,634.34
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	154,512,292.09	253,259,572.47
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.3	Татварын өр	-	
2.1.1.12	Богино хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Эздийн өмч	23,900,942.97	23,900,942.97
2.4	Хуримтлагдсан үр дүн	130,611,349.12	229,358,629.50
2.3.9	Өмнөх үеийн үр дүн	72,391,557.79	130,611,349.12
2.3.10	Тайлант үеийн үр дүн	58,219,791.33	98,747,280.38
2.3.11	Эздийн өмчийн дүн		
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	154,512,292.09	253,259,572.47

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	Борлуулалтын орлого (цэвэр)	186,137,334.00	199,102,944.00
3	Нийт ашиг (алдагдал)	186,137,334.00	199,102,944.00
8	Бусад орлого	138,477,115.51	199,109,944.00
9	Хүүгийн орлого		843,393.24
10	Борлуулалт маркетингийн зардал	-	36,481,032.00
11	Ерөнхий ба удирдлагын зардал	63,139,074.30	137,083,362.68
12	Бусад зардал	5,185,475.99	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	75,338,041.25	26,381,942.56
19	Орлогын татварын зардал	823,442.41	339,724.82
20	Татварын дараах ашиг (алдагдал)	74,514,598.84	26,042,217.74

21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	74,514,598.84	26,042,217.74
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	58,219,791.33	98,747,280.38
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	58,219,791.33	98,747,280.38

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	23,900,942.97	-	-	72,391,557.79	96,292,500.76
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	23,900,942.97	-	-	72,391,557.79	96,292,500.76
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	58,219,791,33	58,219,79,33
2022 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	23,900,942.97	-	-	130,611,349.12	154,512,29.09
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	23,900,942.97	-	-	130,611,349.2	154,512,292.09
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	98,747,280.38	98,747,280.38
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
2023 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	23,900,942.97	-	-	229,358,629.50	253,259,572.47

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	187,390,134.00	199,946,337.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	187,390,134.00	199,102,944.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого		843,393.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	141,812,729.58	167,518,613.98
1.2.1	Ажиллагчдад төлсөн	39,087,207.00	73,630,431.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	11,450,737.74	9,178,803.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	67,687,493.00	29,965,155.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0	-
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0	26,604,813.86
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	5,434,827.84	2,343,761.48
1.2.9	Бусад мөнгөн зарлага	18,152,464.00	25,795,649.64
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	45,577,404.42	32,427,723.02
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	45,577,404.42	32,427,723.02

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	73,215,802.96	118,793,207.38
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	118,793,207.38	151,220,930.40

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл						
2	Нийт орлого	м/төг	187,390,134	240,042,000	199,946,337,24	12,556,143	83.2
	Үүнээс: Цэвэр борлуулалт	м/төг	186,137,334	239,250,000	199,102,944	12,965,610	83.2
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	м/төг	1,252,800	792,000	843.393,24	409406,76	106.4
3	Нийт зардал	м/төг	131,112,729.58	191,713,000	173.904.119,5	17,808,880,5	87.4
	Үүнээс:						
	а) Борлуулалт, маркетингийн зардал	м/төг	123,659,942.73	51,713,000	36,820,756,82	14,892,243,18	71,2
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/төг	7,452,464	140,000,000	137,083,362,68	2,916,637,32	97,9
	в) Хөрөнгө оруулалт их засвар	м/төг	0.00		0.00	0.00	
4	Татварын өмнөх ашиг, алдагдал	м/төг	74,514,598.84	48,329,000	26,042,217.74	22,286,782,26	53,88

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Хүдэр ойн анги ОНӨААТҮГ нь Сэлэнгэ аймгийн Хүдэр Сумын ИТХ-ын 2014 оны 107 дугаар тогтоолоор анх байгуулагдсан бөгөөд 2023 оны 113 дугаар тогтоолоор орон нутгийн хуулийн этгээдийн дүрмийг шинэчлэн баталсан байна.

Хүдэр ойн анги ОНӨААТҮГ нь “Ойгоос бэлтгэх хэрэглээний болон үйлдвэрлэлийн зориулалттай модыг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээлтийг хуулийн дагуу хийлгэх, модны үр, тарьцыг бэлтгэх, зэрлэг ан амьтныг хамгаалах” гэсэн үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Ойгоос бэлтгэх модны талбайг тусгаарлах,
- Бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгох,
- Мод бэлтгэсэн талбай болон хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойг эрүүлжүүлэх, ойжуулалтын ажил хийх, ойн хөнөөлт хортон шавж, өвчний тоймчилсон судалгааг хийх,

- Модны үр, тарьц бэлтгэх ажлыг зохион байгуулах, мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг эрхлэх,
- Ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хяналт тавьж ажиллах,
- Аймаг, сумын түвшинд ойг хамгаалах, зохистой ашиглах нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох,
- Ойн санд амьдардаг зэрлэг ан амьтадыг хамгаалах, өсгөн үржүүлэх, улсын ойн санд таримал ойг хүлээн авах,
- Ойн дагалт баялгийн цаг хугацааны судалгааг хийх, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх хэмжээг тогтоох гэх мэт

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал бөгөөд 100 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сумын ИТХ-ын 2023 оны 113 дугаар тогтоолоор Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ-ын дүрмийг шинэчлэн баталсан байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх” 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,

Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд Хүдэр сумын ИТХ, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

Тайлант онд Сэлэнгэ аймгийн Засаг Даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 98,747.2 мянган төгрөгөөр буюу 1.6 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	118,793.2	151,220.9	32,427.7
Авлага	1,083.0	1,013.6	-69.5
Бараа материал	2,293.5	29,985.4	27,691.9
Үндсэн хөрөнгө	32,342.5	71,039.6	38,697.1
Нийт хөрөнгийн дүн	154,512.2	253,259.5	98,747.2
Өр төлбөр			
Эздийн өмч	23,900.9	23,900.9	
Хуримтлагдсан ашиг	130,611.3	229,358.5	98,747.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	154,512.2	253,259.4	98,747.2

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 151,220.9 мянган төгрөг болж 32,427.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 26,042.2 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаас шалтгаалсан байна.

Бараа материалын данс 29,985.4 мянган төгрөг болж 27,691.9 мянган төгрөгөөр буюу 13.1 дахин өссөн нь өмнөх онд суулгасан модны үр, суулгацыг тайлант онд бараа материалын дансанд өртгөөр нь бүртгэж, тайлагнасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 71,039.6 мянган төгрөг болж 38,697.1 мянган төгрөгөөр буюу 2.2 дахин өссөн нь авсан үрлэгч, цахилгаан үүсгэвэр, усалгааны мотор, бага оврын экскаваторыг балансаас баланст үнэ төлбөргүй шилжүүлэн авсантай холбоотой байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 болон 20 дугаар зүйлийн 20.3-д заасны дагуу Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/06 дугаар захирамжаар тус байгууллагын 2023 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг буюу нийт орлогыг 240,042.0 мянган төгрөгөөр, зарлагыг 161,313.0 мянган төгрөгөөр, ашгийг 78,729.0 мянган төгрөг байхаар баталсан байна.

Хүдэр сумын Засаг даргын 2023 оны 09 дугаар сарын 27-ны өдрийн А/130 дугаар захирамжаар 2023 онд нийт зарлагыг 30,400.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 191,713.0 мянган төгрөгөөр, цэвэр ашгийг 48,329.0 мянган төгрөг байхаар тодотгон баталсан байна.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогоос 137,736.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 62,209.5 мянган төгрөг, нийт 199,946.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 173,564.4 мянган төгрөгийн зардал гарган, 339.7 мянган төгрөгийн орлогын татварыг төлж, 26,042.2 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Сумын ИТХ-аар Хүдэр ойн ангийн орлогыг 240,042.0 мянган төгрөгөөр батлахдаа оны эхний дансны үлдэгдлийн 118,000.0 мянган төгрөгийг тайлант онд төвлөрөх 122,042.0 мянган төгрөгийн орлогод нэмж баталсан байна.

Оны эхний мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг хасч тооцвол гүйцэтгэлээр 199,946.3 мянган төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөөг 77,671.0 мянган төгрөгөөр буюу 63.6 хувиар давуулан биелүүлсэн нь мод үржүүлгийн газрын өмнөх онуудад суулгасан тарьц суулгацыг худалдан борлуулсан, талбай тусгаарлалтын орлогыг бүрэн төвлөрүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Нийт зардлыг 191,713.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 173,564.4 мянган төгрөгийг зарцуулж, зардлыг 18,148.6 мянган төгрөгөөр буюу 9.4 хувиар хэмнэсэн нь цалин,НДШ-ийн зардал хэмнэгдсэнээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүдэр ойн анги ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж байхтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүдэр ойн анги ОНӨААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 186,137.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **1,861.3** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хүдэр ойн анги ОНӨААТҮГ нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Албан конторын их засварын ажлыг хийгээгүй,
- Албан томилолтын зардал гаргаагүй,
- Шинэ жил болон бусад баяр ёслолд зардал гаргаагүй,
- Авлага, өр төлбөр үүсгэлгүй ажилласан гэх мэт.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Хүдэр ойн анги ОНӨААТҮГ нь мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллээс 163 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

Хугацаа хоцроосон:

- Байгууллагын батлагдсан төсвийг 1 удаа,
- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг 3 удаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмж өгөх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 124 дүгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад шууд худалдан авах босго үнээс давсан төсөл арга хэмжээг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн албан шаардлагын биелэлтийг хангаж ажилласан тул биелэлтийг 100.0 хувиар тооцлоо.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Албан шаардлага	1		1		100.0
Нийт дүн	1		1		100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар өмнөх онд суулгасан модны үрсэлгээг тайлант оны бараа материалд орлогоор бүртгэж тайлагнаагүй 22,619.7 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт **1,700.0** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 1,500.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 200.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

1. Гавьяат тариаланч Л.Цандэлэг, аймгийн хурц арслан Д.Төрболд, үндэсний сурын харвааны аймгийн мэргэн Ж.Эрхэмбаяр нарт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 1,500.0 мянган төгрөгийн хандив тусламж үзүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 дахь “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь “үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль зөрчин олгосон хандив тусламжийг төсөвт төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бараа материалын дансанд орлого дутуу бүртгэсэн	1	22,619.7			1	22,619.7	1	22,619.7				
Дүн	1	22,619.7			1	22,619.7	1	22,619.7				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага албан шаардлага		Хууль, хяналтын шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хандив, тусламж үзүүлсэн.	1	1,500.0	1	1,500.0								
Дүн	1	1,500.0	1	1,500.0								

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Зөвлөмж		Хариуцлага албан шаардлага		Хууль, хяналтын шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	1									
Шилэн дансны 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1									
Нийт дүн	1									

/мянган төгрөгөөр/